SMP-04 (Карьер орчим)	3	<1	150	15	15	31.6	1	53	<10	347	116	58
SMP-07 (Засварын газар)	4	<1	128	30	14	28.6	1	45	<10	251	99	79
SMP-08 (ШТС)	3	<1	139	25	16	29.6	1	53	<10	241	110	65
SMP-09 (Нөлөөлөлд өртөөгүй)	19	<1	59	20	11	25.7	1	34	<10	198	73	58
SMP-11 (Хогийн цэг)	13	<1	67	21	12	28.7	1	36	<10	154	81	68
Хүлцэх агууламж	20	3	150	100	50	100	5	150	50	800	150	300



ЗУРАГ № 62 ХӨРС, УС, АГААРЫН ХЭМЖИЛТ



ЗУРАГ № 63 АГААРЫН ДЭЭЖ АВСАН БАГАЖ

4. Ургамлын хяналт шинжилгээ

Ургамлын мониторинг хийхдээ ургамлан нөмрөгийн олон янз байдал, нөлөөллийн зэргээс хамаарч өмнө сонгосон 5 цэгт хийлээ.

ЗУРАГ № 64 УРГАМЛЫН МОНИТОРИНГИЙН ХЭМЖИЛТ ХИЙСЭН ЦЭГҮҮД

№	Координат	Байршил	Цэг сонгосон үндэслэл
Мониторинг -1	E 97°52'49" N 45°22'02"	Хуучин кемпийн хашааны гадна	Төслийн талбай орчмын ургамлан нөмрөгийн суурь нөхцөлийг тодорхойлох зорилгоор сонгов.
Мониторинг -2	E 97°53'33" N 45°22'13"	Уурхайн орчимд	
Мониторинг -3	E 97°53'14" N 45°21'55"	Уурхайн урд толгод орчим	
Мониторинг -4	E 97°52'35" N 45°22'49"	Шинэ Кемп	
Мониторинг -5	E 97°55'05" N 45°21'34"	Хяналтын цэг	

Судалгааны талбайд 2019 оны 6 сард 13 овгийн 28 төрлийн 30 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд 2024 онд 16 овог 29 төрөл 36 зүйлийн ургамал, 2025 оны 7 сард онд 17 овгийн 35 төрлийн 46 зүйл ургамал бүртгэлээ. Энэ талбайд нийт 17 овгийн 38 төрлийн 49 зүйл ургамал бүртгэгдсэн.




ГРАФИК 1 2019,2024,2025 онд БҮРТГЭСЭН ОВОГ, ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙН ТОО ХЭМЖЭЭ

Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно. 2017 онд ургамал ургаж эхэлж байсан бол 2024 онд намар хагдарсан үед тогтсон цэгт судалгаа хийсэн. 2025 онд 7 сард бороо орсоны дараа хийгдсэн.

ХҮСНЭГТ 11 СУДАЛГАА ХИЙСЭН ТАЛБАЙН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

№	Зүйлийн Латин нэр	Зүйлийн Монгол нэр	2019	2024	2025
<i>1. Gramineae Juss.-Үетэний овог</i>					
1	<i>Achnatherum splendens (Trin.) Nevski</i>	Гялгар дэрс	sp	sp	sp
2	<i>Stipa glareosa P.Smirn.</i>	Сайрын хялгана		cop1	sp
3	<i>Stipa klemenzi</i>	Өдлөг хялгана	sp		sp
4	<i>Agropyron desertorum</i>	Цөлийн ерхөг		sp	sp
5	<i>Leymus chinensis</i>	Нангиад түнгээ		sol	sp
6	<i>Stipa krylovii</i>	Шивээт хялгана	sol	sol	sp
<i>2. Cyperaceae Juss. - Улалжийн овог</i>					
7	<i>Carex duriuscula C.A.Mey.</i>	Ширэг улалж	sol	sol	sp
8	<i>Carex stenophylloides</i>	Утсан навчит улалж		sol	sp
<i>3. Asparaginaceae- Хэрээнүдэнгийн овог</i>					
9	<i>Asparagus gobicus Ivanova.ex Grub.</i>	Говийн хэрээн нүд	sol	sp	sp

Судалгааны талбайд нийт 49 зүйлийн ургамалт бүртгэдсэнээс энд эхний 9-н зүйлийг дурдав. Дэлгэрэгүйг ОХШ-ын тайлангаас харна уу.

Хээрийн өндөр уул түүний хөндийн өдлөг хялганат, бүс дундын дэрст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 10-35%, 100 м2 талбайд 9-14 зүйлийн ургамал тэмдэглэгдсэн бөгөөд дундаж ургац 2,3 ц/га.

“Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл” (2012), “Монгол орны улаан ном” (2013)-ын ургамлын жагсаалтад орсон нэн ховор, ховор ургамлын зүйлүүд тэмдэглэгддэггүй. БОНХАЖЯ-ны 2015 оны 282 дугаар сайдын тушаалаар батлагдсан Ашигт ургамлын жагсаалтанд элбэг тархалттай 4 зүйл (*Orostachys spinosa* -үлд өвс, *Astragalus galacitites* -Шүдэн цагаан, *Convolvulus ammannii*- Аммонний сэдэргэнэ, *Arenaria capillaris*- хурдан цагаан) ургамал ургана. Бэлчээрийн талхагдал бага байна.

2019 оны БОННУ-ний тайлангийн ургамлын судалгаатай тохирч байгаа бөгөөд ургамлан нөмрөгийн бүрхэц, зүйлийн бүрдэл нь буурсан байна. Энэ нь сүүлийн жилүүдэд хур тунадас бага унасан, цаг уурын өөрчлөлттэй холбоотой.



2024 он



2025 он

Мониторингийн цэгийн өөрчлөлт

Төслийн талбайд 2024 онд хавар судалгаа хийсэн бол 2025 онд зун 7 сарын эхээр хур тунадас орсны дараагаар хийгдсэнээрээ онцлог. Мониторингийн цэгийн өөрчлөлтийг дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 12 Мониторингийн цэгүүдийн харьцуулалт

№	Бүлгэмдэл	Тусгагийн бүрхэц, %		Зүйлийн бүрдэл		Ургац, ц/га	
		2024	2025	2024	2025	2024	2025
Мониторинг -1	Дэрс бүхий агь	26	57	10	11	1.3	4.2
Мониторинг -2	Нэг наст бүхий үетэн (Agropyron desertorum, Stipa glareosa, Stipa krylovii)-сэдэргэнэт	19	31	10	15	1.8	3.1
Мониторинг -3	Сайрын хялганат	31.5	34	12	19	1.6	1.9
Мониторинг -4	Нэг наст бүхий ерхөгт	18	33	8	16	1.5	3.3
Мониторинг -5	Сайрын хялганат	36	51	12	14	2.1	2.8

2025 онд төслийн талбайн ургамлан нөмрөг түүний бүрхэц, зүйлийн бүрдэл, ургац нэмэгдсэн. Мониторингийн 4 цэг нь өмнө нь сайрын хялгана- таанат бүлгэмдэлтэй байсан бөгөөд хашаалж хамгаалсанаар өндөр уулын үндсэн нэг наст бүхий ерхөгт бүлгэмдэл үүссэн.

Товч дүгнэлт :


Судалгааны талбайд 2019 оны 6 сард 13 овгийн 28 төрлийн 30 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд 2024 онд 16 овог 29 төрөл 36 зүйлийн ургамал, 2025 оны 7 сард онд 17 овгийн 35 төрлийн 46 зүйл ургамал бүртгэлээ. Энэ талбайд нийт 17 овгийн 38 төрлийн 49 зүйл ургамал бүртгэгдсэн. 2025 онд нэг овог, 7 зүйл нэмж тэмлэглэлээ. Тус талбайд ургамалжлын судалгаагаар цөл, цөлөрхөг хээрийн ургамалжилтай. Мониторингийн цэгүүд 11-19 зүйл ургамалтай бөгөөд 1 мкв талбайд 6-9 зүйл тохиолдоно. Ургамлан нөмрөгийн бүрхэц 31-51% бүрхэцтэй. Дундаж ургац 3 ц/га. 2025 онд төслийн талбайн ургамлан нөмрөг түүний бүрхэц, зүйлийн бүрдэл, ургац нэмэгдсэн. Мониторингийн 4 цэг нь өмнө нь сайрын хялгана- таанат бүлгэмдэлтэй байсан бөгөөд хашаалж хамгаалсанаар өндөр уулын үндсэн нэг наст бүхий ерхөгт бүлгэмдэл үүссэн.

5. Амьтны аймгийн хяналт шинжлгээ

Энэ бүс нутгийн шүхэр зүйл буюу хамгааллын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бусад биологийн олон янз байдал нь дам байдлаар хамгаалагдах, судалгааны мэдээллийн сан үүсэх боломжтой зүйлээр Монгол тарвага (*Marmota sibirica*) -ыг сонголоо. Энэ зүйл нь энэ бүс нутагт харьцангуй нягтшил өндөр хэдий ч улсын хэмжээнд жил бүр тоо толгой нь буурч, зарим газарт бүрэн утсанаар сэргээн нутагшуулах ажил хийгдэх болоод буй устаж болзошгүй зүйл юм. Сүүлийн үед гадаад, дотоодын судалгааны байгууллагуудын хамгийн түгээмэл ашиглаж буй автомат камерын аргаар монгол тарваганы тандалт судалгааг хийх боломжтой төдийгүй аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс болон бусад мах идэшт амьтдын тоо толгойн мэдээллийг цуглуулах боломж бүрдэнэ. Чандмань сумын нутагт буй монгол тарваганы үндсэн тархац бүхий газраар 14 автомат камерыг 3 сарын 15-аас 10 сарын 01 хүртэлх хугацаанд байрлуулснаар тухайн зүйлийн зан төрх, хонгийн идэвхжилийг ичээнээс гарсны дараах үе, ороо хөөцөөний үе, үржлийн үе, ичээлэхийн өмнөх үе гэх мэтээр мэдээлэл цуглуулах боломжтой. Мөн энэхүү ажил нь тухайн зүйлийн хууль бус агнуурт өртөх эрсдэлийг бууруулах боломжтой.

Хүснэгт 13 АВТОМАТ КАМЕР БАЙГУУЛАХ БОЛОМЖИТ БАЙРШЛЫН САНАЛ

№	Уртраг	Өргөрөг	Камерын №
1	98°13'59.09"E	45°6'31.24"N	#001
2	98°13'13.067"E	45°9'29.956"N	#002
3	98°6'56.514"E	45°10'57.756"N	#003
4	98°0'47.879"E	45°12'54.087"N	#004
5	97°55'9.282"E	45°13'40.408"N	#005
6	97°56'4.398"E	45°16'27.604"N	#006
7	97°50'17.527"E	45°16'30.395"N	#007
8	97°50'35.122"E	45°18'48.443"N	#008
9	97°34'22.344"E	45°21'48.805"N	#009
10	97°39'12.216"E	45°21'11.171"N	#010
11	97°45'13.489"E	45°19'26.213"N	#011
12	97°34'30.192"E	45°24'21.174"N	#012
13	97°39'11.668"E	45°23'37.263"N	#013
14	97°45'4.445"E	45°21'52.213"N	#014





БҮЛЭГ 9.

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**


9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Эрүүл мэндийн үзлэг

Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгийг “Гранд мед” эмнэлэгтэй ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан 2025 оны 10 дугаар сарын 1-ээс 15-ны өдрүүдэд нийт 29 ажилтныг (15 эрэгтэй, 14 эмэгтэй) урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан

Уул уурхайн олборлолтын ажил гүйцэтгэж буй туслан гүйцэтгэгч компани Хэлт роуд ХХК-тай Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, хугацаат үзлэгийн гэрээ байгуулан нийт ажилтныг хамруулдаг.

Кемпийн үйлчилгээний ажилтнууд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 191дүгээр тушаалын 20 дугаар хавсралтаар батлагдсан байсан гэрээг нэмэт өөрчлөлтөөр сунгалт хийсэн. Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудасд заасны дагуу хоол үйлдвэрлэл болон үйлчилгээний ажилчдыг 6 сар тутамд бусад ажилчдыг 1 жил тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулан цагаан дэвтрээр баталгаажуулдаг.



Зураг №60. Эрүүл мэндийн үзлэгийн гэрээ

2.Хамтран ажиллах гэрээ

Нийгмийн хариуцлагийн гэрээтэй холбоотой 2025 оны 10 сарын 29-нд сонголын үйл ажиллагаанд гэрээний хэрэгжилтийн талаар тайлагнасан.

Нөгөөтгээгүүр нийгмийн хариуцлагын хүрээнд суманд хийгдсэн бусад ажлын тайланг хавсралтад хавсаргав.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧТЭЙ
БАЙГУУЛСАН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

ГЭРЭЭНИЙ ДУГААР 2025/20.....

202502010058

2025 он

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2025 оны 04-р сарын 11-ний өдөр

№ 2025/20

Алтай хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загварыг үндэслэн
Нэг талаас Говь-Алтай аймаг, түүнийг төлөөлж (цаашид "Орон нутгийн захиргаа" гэх) аймгийн Засаг дарга Г.Чинбат, Чандмань сумын Засаг дарга Б.Эрдэнэ-Очир (цаашид хамтад нь "Орон нутаг" эсхүл "Засаг дарга" гэх) Нөгөө талаас "Сэкер ресорсус монголиа" ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Баттуул (цаашид "Компани" гэх) нар нь харилцан тохиролцож авлигаас өнгөд байж, нийтийн ашиг сонирхлыг ханган ажиллахаа илэрхийлж 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү гэрээгээр талууд Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжил дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолтын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, талуудын ажлын үйлдвэр холбоогүй ажлаартай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг дахь "Сэкер ресорсус монголиа" ХХК-ийн MV-017438, MV-014217, MV-011966, MV-000906 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд талууд хамтран ажиллана.

1.3.Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн асуулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд, Байгаль орчныг хамгаалах тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын тухай багц хуулиуд болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хүрээнд явагдана.

1.4.Компани гэдэгт тус аймагт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх компани болон түүний охин, хараат болон хамаарал бүхий компаниудыг нэгтгэж ойлгоно.

1.5.Энэхүү гэрээг хэрэгжүүлэхэд талууд эрх бүхий байгууллагаас баталсан тухайн ордыг цогцоор нь хөгжүүлэх урт хугацааны стратегийн хөтөлбөр, бизнес төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин ажиллана.

1.6.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ЗАРЧИМ

2.1.Энэхүү хамтран ажиллах гэрээний хүрээнд гэрээг хэрэгжүүлэхэд Талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:

2.1.1.Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх;

2.1.2.Байгаль орчныг хамгаалах;

2.1.3.Ажлын байрыг нэмэгдүүлэх;

2.1.4.Орон нутгийн хөгжлийг дэмжих/мөнгө, хандив тусламж/

2.2.Орон нутгийн захиргааны байгууллага нь Компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Компани нь энэхүү гэрээнд заасан хүрээнд орон нутагт дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Компани нь энэхүү гэрээнд зааснаас өөр үүргийг орон нутгийн өмнө хүлээхгүй.

2.3.Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн зэрүүнд уурхай байрлах буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахад анхаарч ажиллана.

3.Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох журам боловсруулж, мөрдөж ажиллах

- ✓ Хог хаягдлын журам
- ✓ Өнгөн хөрстэй ажиллах журам
- ✓ Асгаралтын журмыг боловсруулан, батлуулсан. Цаашид үйл ажиллагаа жигдрэх үед нэмэлт өөрчлөлт, сайжруулалтыг хийж ажиллана.

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА **Хог хаягдлын журам**

ХОГ ХАЯГДЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- Энэхүү журмын зорилго нь "Сэкер Ресорсуус Монголиа" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн уурхайн үйл ажиллагаанаас гарах энгийн болон аюултай хог хаягдал, тэдгээрийг эх үүсвэр дээр нь багаагах, бууруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар зайлуулах, хадгалах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- Энэхүү журам нь Компанийн уурхайн бүх хэсэг, нэгж, туслан гүйцэтгэгч гэрээт компани, тэдгээрийн ажилтнууд, түр зочлоод нэгэн адил хамаарна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖИЛТ

- Байгаль орчны мэргэжилтэн журмын хэрэгжилтийг хангуулах буюу үл нийцлийг арилгуулахад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, нэгдсэн бүртгэлийн сан хөтөлж мэдээлэлд статистик шинжилгээ хийх, эргэх холбоог хангах, тэмдэглэл хөтлөхөд үндэслэн тогтолцоонд байнгын сайжруулалт хийх.
- Нийт нэгжийн удирдлагууд журмын хэрэгжилтийг хангуулах.
- Нийт нэгж, гэрээт аж ахуй нэгжийн аюултай хог хаягдлын удирдлагыг Компанийн менежментийн төлөвлөгөөний дагуу хариуцаж ажиллах.
- Гэрээт аж ахуй нэгжийн байгаль орчны мэргэжилтэн, ажилчдын хотхон хариуцсан менежерүүд, категориний үйлчилгээний ажилтнууд журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАЛ, ТӨРӨЛ

- Уурхайн оффис, ажилчдын хотхон, засварын цех, яаралтай тусламжийн хэсгээс гарах бүхий л төрлийн хог хаягдлыг хамруулах ба дараах байдлаар ангилна. (Хог хаягдлын нэр төрөл нь дараах байдлаар хязгаарлагдахгүй.) (Хавсралт №1)

3.1.1. Энгийн хог хаягдал

- 3.1.2.1. Ус, ундааны хуванцар савыг **НОГООН** өнгийн саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт хүргэнэ;
- 3.1.2.2. Хоол үйлдвэрлэлээс гарсан хүнсний хаягдал, хоолны үлдэгдлийг категориний Компанийн үйлчилгээний ажилчид ангилан ялгаж БОР өнгийн саванд цуглуулж, органик бордоо болгох дэвшилтэт технологийг туршина;
- 3.1.2.3. Бусад төрлийн хог хаягдал буюу сандфета, ариун цэврийн цаас, гялгар уут, нэг удаагийн хоолны пакет, таваг, анги, шаазан зэвсэг, давуу гэх мэтний энгийн хог хаягдал хадгалах буюу **ХАР** өнгийн саванд цуглуулж нэгдсэн хогийн цэцгэ хүргэнэ;

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА **Өнгөн хөрстэй ажиллах журам**

ӨНГӨН ХӨРСТЭЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- Энэ журмын зорилго нь "Сэкер Ресорсуус Монголиа" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн уурхайн олборлолт, бүтээн байгуулалтад өртөж байгаа талбайгаас шимэрхэг чулуулаг болон шимт хөрсийг нөхөн сэргээлтийн зорилгоор ашиглахад зориулж хуулах, хадгалах, тээвэрлэх технологийг тодорхойлоход оршино.
- Өнгөн хөрсийг эргүүлэн ашиглах ажиллагаа нь нөхөн сэргээлтийн бусад бичиг баримтаар зохицуулагдана.
- Энэ журам нь Компанийн болон уурхайн бусад үйл ажиллагаа явуулж буй гэрээт, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн ажилтнуудад нэгэн адил хамаарна.

ХОЁР. НЭР ТОМЬЕОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Шимт хөрс гэж ургамал ургахад шаардагдах уржил шим, агрохим, механик бүрдэл бүхий нөхцөлийг хангасан буюу энгийн сайжруулалт хийх боломжтой хөрсний өнгөн хэсгийг ойлгоно.
- Шимэрхэг хөрс гэж ургамлын ургалт, төлжилтөд хязгаарлагдмал хүрээнд таатай нөлөө үзүүлэхүйц физик, хими шинж чанар бүхий уулын чулуулгийг ойлгоно.
- Нөхөн сэргээлтэд ашиглагдах боломжтой хөрсний гадаргуугийн дээд хэсгийг буюу шимт хөрс болон шимэрхэг хөрсийг хамтад нь өнгөн хөрс гэж ойлгоно.
- Хөрсний урьдчилсан үнэлгээ гэж үйл ажиллагаа явуулах талбайн шимт хөрсийг хуулахаас өмнө хөрсний чанарыг магадлан нөөцийг хэсэгчлэн тогтоох ажиллагаа бөгөөд уг үнэлгээгээр шимт болон шимэрхэг хөрс хуулах зузааныг тогтооно.

ГУРАВ. ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Тухайн жилд уурхайн ажилтад өртөж хуулагдах талбай, өнгөн хөрс, ялангуяа шимт хөрсний хэмжээ болон овоолго үүсгэн байрлуулах талбайн байршил, хэмжээг ашиглалтын үйл ажиллагааны болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байна.
- Шимт хөрс хуулахаас өмнө талбайд цэвэр усны эх үүсвэр хөндөгдөх, ховор ургамал өртөх эсэхийг тогтоон шаардлагатай бол нөхөн сэргээлтийн талбайд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж хийж гүйцэтгэнэ.

ДӨРӨВ. ӨНГӨН ХӨРС ХУУЛАХ ЯВЦ

- Байгаль орчны мэргэжилтэн хөрсний урьдчилсан үнэлгээ, уулын ажлын төлөвлөгөө болон бусад төлөвлөлтийг үндэслэн шинээр газар хөндөх, хөрс хуулах тохиолдол бүрд шимт хөрс хуулах зөвшөөрөл олгоно.

Хуудас 2 / 9

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА **Газар хөндөх журам**

ГАЗАР ХӨНДӨХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- Энэ журмын зорилго нь "Сэкер Ресорсуус Монголиа" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн уурхайн бүсэд хийгдэх аливаа газар хөндөх ажлыг төлөвлөж, гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- Энэхүү журмын зорилго нь уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй үндсэн болон гэрээт аж ахуйн нэгжийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.
- Энэ журам ашигласнаар зохицуулагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, дүрэм, журам болон заавраар зохицуулна.

ХОЁР. ГАЗАР ХӨНДӨХ БЭЛТГЭЛ АЖИЛ

- Газар хөндөх ажлыг удирдан гүйцэтгэх ажилтан тухайн ажлын төлөвлөгөөг байгаль орчны мэргэжилтний хамт боловсруулж, зураг төслийн хамт уурхайн удирдлагад хүргүүлнэ.
- Аливаа газар хөндөх ажлыг удирдаж байгаа ажилтан нь ажлаа эхлэхийн өмнө түүнд тохирсон арга технологи, техник, тоног төхөөрөмж сонгож авсан эсэхийг урьдчилан шалгах, бэлтгэл ажлаа хангана. Мөн эдгээр техник тоног төхөөрөмжийг ажиллуулах хүмүүс шаардлагатай сургалт зааварчилгаанд хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхтэй эсэхийг шалгах, баталгаажуулсан байна.
- Тухайн орчинд байгаа эрчим хүчний эх үүсвэрийг олж тэмдэглэн журмын дагуу бүрэн тусгаарлаж салгасан байх шаардлагатай бөгөөд салсан эсэхийг мэргэжлийн ажилтнаар шалгуулсны дараа уг ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоно.
- Энэ журмын 2.3-т заасанчлан бүрэн тусгаарлах боломжгүй тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Ажлын аюулын шинжилгээ хийсний дараа шаардлагатай эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч журмын дагуу ажиллана.

ГУРАВ. ГАЗАР ХӨНДӨХ ЗӨВШӨӨРӨЛ

- Газар хөндөх ажил хийх нэгжийн ажлаа ажилтан нь энэ журмын хавсралтад заасан маягыг бөглөн холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж газар хөндөх зөвшөөрлийн хүснэгт (Хавсралт 1)
- Газар хөндөх тухай хүсэлт болон түүний дагалдах материалд дор дурдсан мэдээллийг оруулсан байна.
 - Газар хөндөх зөвшөөрөл хүссэн ажилтны мэдээлэл;
 - Газар хөндөх ажлын төлөвлөгөө;

СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА **Холын аяллын журам**

ХОЛЫН АЯЛЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- Энэхүү журам нь аялал гүйцэтгэхэд жолооч, зорчигчийн аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хянах, аялагчид төлөвлөсөн газарт хугацаандаа хүрээгүй тохиолдолд шаардлагатай тусламжийг үзүүлэхэд оршино.
- Тээврийн хэрэгслийг жолоодож буй томилгоосон жолооч нь: өөрийн жолоодож буй тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, техникийн үзлэг, зорчигчийн аюулгүй байдал аюулгүй жолооллыг бүрэн хариуцаж Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг баримтлан хөдөлгөөнд оролцоно.
- Улаанбаатар хот, Уурхай болон хээрийн анги, бүсээс гадна хөнгөн тэрэг жолоодож буй бүтээгдэхүүн дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:
 - 1.3.1 Монгол Улсын жолооны үнэмлэхтэй (ангилал тохирч байх)
 - 1.3.2 21 нас хүрсэн ба түүнээс дээш
- Байгууллагын тээврийн хэрэгсэл жолоодож буй бүх жолооч нь байгууллагын тээврийн хэрэгсэл жолоодогч "Ажлын байрны тодорхойлолт"-д тусгаснаар хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- "Сэкер Ресорсуус Монголиа" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн дотоод үйл ажиллагаанд хүрээнд гүйцэтгэж буй бүх аялал хамаарна.

ГУРАВ. НЭР ТОМЬЕОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Энэхүү журамд дурдсан нэр томьёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
 - 3.1.1 "Аялал" – гэж Улаанбаатар хот, Уурхай болон Хээрийн ангиас гадагш тээврийн хэрэгсэлээр замын хөдөлгөөнд оролцохыг хэлнэ.
 - 3.1.2 "Томилгоосон жолооч" – гэж хээрийн ангиас гадна хөнгөн тэрэг жолоодох үүдвэр бүхий дадлага туршлагатай, байгууллагын тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй этгээдийг хэлнэ. Жолооч томилгоо тээврийн алба нэгжийн удирдагч ажилтан томилж харьяалах газар, хэлтсийн захирал аялал гүйцэтгэхийг баталгаажуулна.
 - 3.1.3 "Ажлын аялагч" – гэж байгууллагаас тухайн аяллын үед шууд удирдлагаа хангахаар томилгоосон ажилтан.
 - 3.1.4 "Ажлын удирдагч" – гэж тээврийн хэлтсийн шууд удирдлагаар хангах эрх бүхий газар, нэгжийн захирал байна.
 - 3.1.5 "Онцгой байдал" – гэж осол авар тохиолдсон эсвэл хүний эрүүл мэнд амь насанд аюултай байдал үүссэн нөхцөлийг хэлнэ.

Зураг №61. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр боловсруулан батлуулсан журмууд

5. Байгаль орчны аудитын тайлан

Төлөвлөгөөт байгаль орчны аудитын зөвлөмжөөр хүргүүлсэн үл нийцлийг арилгасан тайланг хавсралтад тусгав.

6. Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах

✓ Говь-Алтай аймгийн Байгаль орчны газраас Зээгийн уурхайн унд ахуй болон тоосжилт бууруулах усалгаанд ашиглах усны дүгнэлт гаргуулж, тус гэрээг үндэслэн Чандмань сумын засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулсан. Ус ашиглуулах дүгнэлтэд заасны дагуу зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах усны төлбөрт 1,042,944 төгрөг, унд ахуйд ашигласан усны төлбөрт 189,832.1 төгрөгийг Говь-Алтай аймгийн төсөвт төвлөрүүлэхээс унд ахуйн усны төлбөрийн бүтэн төлсөн ба тоосжилт бууруулах зорилгоор ашигласан усны төлбөрийг баталгаажсан тоолуурын заалтаар тооцсон бөгөөд 399,034.72 төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлээд байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТӨСВИЙН ТОВЧ ЗАДАРГАА

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал / төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	4,998,000
2	Нөхөн сэргээлт	11,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах ажил	49,900,000
4	Түүх соёлын өвийг хамгаалах	Үйл ажиллагааны зардлаас
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардлаас
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	18,550,000
8	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,500,000
	Нийт зардал	90,549,800



БҮЛЭГ 10.

**ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ,
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**



10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1.Сумын засаг даргад урьдчилсан тайлан хүргүүлэх -2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн.

Нөлөөллийн бүсийн иргэдэд уурхайн үйл ажиллагаа танилцуулах -Чандмань сумын Талын шанд болон Эрдэнэ уул багуудын засаг дарга нарт тухайн жилийн БОМТ-ний биелэлт танилцуулахаар БИНХ зарлуулах талаар хүсэлт хүргүүлж, 2025 оны 10 дугаар сарын 04 болон 12 сарын 2-ний өдрийн багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулсан. Багийн хурлын үед иргэд дараах саналыг хэлж байсан. Үүнд:

- Иргэдийн нүүрс олголтод шиггүүр ашиглаж өгөх
- Чандмань сумын 4-н уулан биотехникийн арга хэмжээний өвсийг тавих
- Иргэдэд нүүр олгож байх үед усалгааг хийх

гэсэн санал гарсан бөгөөд 4-н уулан өвс тавих саналыг шийдвэрлэн энэ жил тус бүр 50ш өвсийг тавихаар нөөцийг бүрдүүлсэн. Шигшүүрийг эрх жилийн олголтод ашиглах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана. 10-р сард усалгааг хийж ажилласан цаашдид мөн хийх болно.



Зураг № 62. Багийн иргэдийн нийтийн хурлын танилцуулга

11. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1 ШИМТ ХӨРСНИЙ ЗӨВШӨӨРӨЛ



Өнгөн хөрстэй ажиллах журам

"Өнгөн хөрстэй ажиллах журам"-ын
Хавсралт №1

ШИМТ ХӨРС ХУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:	2025.01.11	Хүсэлт гаргасан хэлтэс/гэрээт компани:	Архэт Түмн
Хүсэлт гаргасан ажилтны овог нэр:	П. Пурьдгалай		
Утас:	95190020	Албан тушаал:	АЛБГА. Чувьн мастер.
Шимт хөрс хуулах байрлал:	Уурхай <input checked="" type="checkbox"/>	Хотхон <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>
Шимт хөрс хуулах байрлал/бичгээр/	Чандмонь сум Зээгийн уурхай.		
Байрлалын талаарх нэмэлт тайлбар:	отвоол талалт.		
Зориулалт:	Уурхайн отвоол талалт.		
Шимт хөрс хуулах талбай:	25 га	га	2000 м2
Хуулагдах шимт хөрсний хэмжээ /м3/	6000 м3.	Байршуулах овоолгын дугаар:	6.
Байршуулах овоолгын талаарх нэмэлт тайлбар:	Шимт хөрс овоолоо.		
Шимт хөрс хуулж эхлэх огноо:	2025.1.11	Дуусах огноо:	2025.1.13
Хариуцах ажилтны овог нэр:	П. Пурьдгалай		
Албан тушаал:	Чувьн мастер.	Холбоо барих утас:	95190020
Бусад мэдээлэл: /Байгаль орчны мэргэжилтэн бөглөнө/			
Газрын хэлбэр:	Тал газар <input checked="" type="checkbox"/>	Хонхор газар <input type="checkbox"/>	Гүвээ <input type="checkbox"/>
Унд, ахуйн болон бусад ундны эх үүсвэрт ойр байгаа эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
Ховордсон амьтан, ургамал өртөх эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
Бохирдол хязгаарлах арга хэмжээ явуулах шаардлагатай эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
Шимт хөрс хуулах гүн/см/	30	Шаардлагатай тохиолдолд хуулах гүн/см/:	20
Шөнийн цагаар хуулах шаардлагатай эсэх?	Үгүй		
Ажлын явцад байгаль орчны нөлөөллийг хянах талаар тэмдэглэл:	Тооцмолгүй бүхрүүлэх		
Байгаль орчны нөхцөл байдлын талаар тэмдэглэл:	Соруу. Хүйтэн уурас		
Ховор ургамлын мэдээлэл:	Үгүй		
Хамгаалах арга хэмжээний талаар:	Үгүй		
Мэргэжилтнүүд бөглөнө:			
Хариуцлагатай ажилтны зөвшөөрөл/гарын үсэг зурж зөвшөөрөл өгснөөр баталгаажуулна/			
Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Огноо
Төлөвлөлтийн инженер:	Г. Энхтүвшин	[Signature]	2025.01.11
Байгаль орчны мэргэжилтэн:	П. Пурьдгалай	[Signature]	2025.01.11
Хариуцан хийх албан тушаалтан:	П. Пурьдгалай	[Signature]	2025.01.11
Хяналт шалгалт: /Байгаль орчны мэргэжилтэн бөглөнө/			
Сар, өдөр	Хуулалт	Тээвэрлэлт	Тайлбар
2025.01.11	20,000 м ³	Шимт хөрс 3	Зох. [Signature]

СРМ-ХЗ-Ж09-Х01

Хуудас 6 / 10

ХАВСРАЛТ 2 ГАЗАР ХӨНДӨХ ЗӨВШӨӨРӨЛ



Газар хөндөх зөвшөөрөл олгох журам

"Газар хөндөх журам"-ын Хавсралт №1

ГАЗАР ХӨНДӨХ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

Хүсэлт гаргагч бөглөнө:

Хүсэлт гаргасан огноо:	2025.01.07.	ГХЗ №	6
Хүсэлт гарсан хэлтэс / Гэрээт компани/:	Хонгоралтай тал		
Хүсэлт гаргасан ажилтны нэр:	А.Лурвугасан	Утасны дугаар:	80855557
Хэлтэс нэгж:	Уу	Албан тушаал:	Ууны мастер
Газар шорооны ажлын байршил (Тодорхой бичнэ үү):	Бондмонь сум Зүүт уурхай, Төв-Армал аймал		
Байрлалын талаар нэмэлт тайлбар:	Кавертгаар зураг. Бондмонь сум Зүүт уурхай		
Газар хөндөх шалтгаан:	<input type="checkbox"/> Барилгы ажил	<input checked="" type="checkbox"/> Хөрс хуулах	<input type="checkbox"/> Шинэ зам тавих
<input checked="" type="checkbox"/> Өнгөн хөрс хуулах	<input type="checkbox"/> Мод ургамал тарих	<input type="checkbox"/> Хог / Бохирын нүх ухах	
<input type="checkbox"/> Хавлт, хашаа барих	<input type="checkbox"/> Бусад (Бичнэ үү):		
Газар доорх болон дээрх байгууламжийг зурагт тэмдэглэж хавсаргасан эсэх:	<input type="checkbox"/> Тийм		<input checked="" type="checkbox"/> Үгүй
Ажлын тодорхойлолт (Уг ажлыг гүйцэтгэх арга, төлөвлөгөө, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг товч тодорхой тусгана)	АБ-аа газарт Нэгдэх Ажилчид Ажиллагааг зөвхөн нэрэгдэж байгаа Ууны Мастерт Хяналт Тавих.		
Ажил дуусахад нөхөн сэргээлтийг хэрхэн хийх тухай мэдээлэл:			
Нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө:	Хийнхүй		
Өртөх талбайн хэмжээ (м²)	6000	Хөрс хуулалтын хэмжээ(м³)	6000
Үүнээс:	<input checked="" type="checkbox"/> Шинэ хөрс (м³) 6000	<input type="checkbox"/> Хаягдал хөрс (м³)	
Ажил гүйцэтгэх хугацаа:	Эхлэх цаг:	08.00	Огноо: 2025.1.12
	Дуусах цаг:		Огноо:
Хяналт тавих нөхцөл	Байгаль орчно тухай.		
	Ууны Мастер хяналт, АБ-аа хяналт.		
Газар дээр нь хяналт тавих ажилтнууд:			
СРМ-ийн төлөөлөл:		Гэрээтийн төлөөлөл:	
Овог нэр:		Овог нэр:	А. А. Амар.
Овог нэр:		Овог нэр:	Г. Эрдэнэтулга
Овог нэр:		Овог нэр:	
Баталгаажуулалт:			

СРМ-ХЗ-Ж08-Х01

Хуудас 9 / 12



Газар хөндөх зөвшөөрөл олгох журам

Тухайн ажлыг газар дээр нь зохион байгуулах ажилтан:

Овог нэр:	<i>Н. Лувьдгалай</i>	Албан тушаал:	<i>Уулын мастер</i>
Энэхүү ажлыг гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцох бүх ажилтан өөрсдийн ажил үүрэгээ, дээр тодорхойлсон ёсоор аюул эрсдэлгүй аргаар, цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөхцөлөөр хангаж ажиллах үүрэг хариуцлага хүлээсэн гэдгээ ! миний бие ойлгож хүлээн зөвшөөрч байна.			
Гарын үсэг:	<i>А.Түвш</i>	Огноо:	<i>2025-01-11</i>

* Байгаль орчны мэргэжилтэн бэглэнэ:

Байгаль орчны асуудал:

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, хүрээнд байгаа эсэх?	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Төрийн байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй
Унд, ахуйн болон бусад усны эх үүсвэрт ойр байгаа эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй
Ховордсон амьтан ургамал өртөх эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй
Бохирдол хязгаарлах арга хэмжээ авагдах шаардлагатай эсэх?	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй
Тоосны эх үүсвэрийг багасгах шаардлагатай эсэх?	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй

Ажлын явцад байгаль орчны нөлөөллийг хянах талаар тэмдэглэл:

- Байгаль Орчны Хяналт Тоосныг бууруулах.

Байгаль орчны нөхцөл байдлын талаар тэмдэглэл:

Усанга хийх. / Гэрлийг нийлж хийх /

Ажил дууссаны дараа нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн тухай тэмдэглэл:

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

З-БОХ-1.3

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ**

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар	2	8	6	2	4	6	8
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	"Сэкер Ресорсус Монголиа" ХХК						
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл	Говь-Алтай аймаг			8	2		
Сум, дүүрэг	Чандмань сум			4	6		

1. Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт маягтаар ирүүлнэ.

2. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн газарт цахим хэлбэрээр ирүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчны мэдээллийн төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

3. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээг хянаад 2 дугаар сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгж нь мэдээг хянаж, нэгтгээд 3 дугаар сарын 10-ны дотор статистик хариуцсан нэгжид цахимаар болон маягтаар ирүүлнэ.

6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимаар болон маягтаар ирүүлнэ.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн дугаар	M	V	0	0	0	9	0	5
	M	V	0	1	1	9	6	5
	M	V	0	1	4	2	1	7
	M	V	0	1	7	4	3	8
Тусгай зөвшөөрлийн талбай, га								
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	1	9	8	0	0	1	0	1
Ашигт малтмалын төрөл	Нүүрс							
Ашиглалтын төрөл	Ил уурхай							

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд (ашиглалт хийсэн)
				2
A	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	х	х
Ашигласан талбай	2	га	26.9	5.92
	3	мян.м ³	2237.489	623.31
Хаягдал чулуулгийн овоолго	4	га	1.72	0
	5	мян.м ³	50	0
Хөрсний овоолго	6	га	41.9	14.6
	7	мян.м ³	1880.713	810.30
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	га	7.6	
Бусад	9	га	7	

4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн	Биологийн
				2	3
A	Б	В	1		
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	310.4		
	11	мян.м ³	1431.85	х	х
Тайланд онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	10	10	
	13	мян.м ³	0		х
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр14≥ мөр16, мөр15≥ мөр17	14	га	10	10	
	15	мян.м ³	0		х
Тайланд онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	10	10	
	17	мян.м ³	0		х
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал, мөр18≥ мөр19	18	мян.төг	0		
	19	мян.төг	49,900,000	49,900,000	
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20≥ мөр21	20	мян.төг	35,000,000	х	х
	21	мян.төг	35,000,000	х	х
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр22≥ мөр23	22	мян.төг	70,000,000	х	х
	23	мян.төг	66,000,000	х	х

ТАМГА

Гүйцэтгэх захирал /Б.Баттуул/

Ерөнхий нягтлан бодогч /Г.Дуламсүрэн/

2025 оны 10-р сарын 30 -ны өдөр



БАТЛАВ:

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЧАНДМАНЬ
СУМЫН ЗАСАГ ДАРГА


Б.ЭРДЭНЭ-ОЧИР

БАТЛАВ:

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-
НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Б.БАТТУУЛ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 09 дүгээр сарын 09

№ 202502010313

Чандмань сум

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү УС АШИГЛАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-г

Нэг талаас Ус ашиглуулагчийг төлөөлж Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг Даргын Тамгын Газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Балган овогтой Өлзийсайхан

Нөгөө талаас Ус ашиглагчийг төлөөлж 2862468 регистрийн дугаартай “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Ч.Төрбат

нар (хамтад нь “Талууд” гэх) Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэг, Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 232 тоот Ус ашиглуулах дүгнэлт, Чандмань сумын Засаг даргын дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- Унд ахуй;
- Зам талбайн тоосжилт бууруулах

2.2. Ашиглах нийт усны хэмжээ: 11,929.8 м³/жил

- Унд ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ: 2,329.8м³/жил
- Зам талбайн тоосжилт бууруулах зориулалтаар ашиглах усны хэмжээ: 9600м³/жил

2.3. Ус ашиглах гэрээний хугацаа: Энэхүү Гэрээ байгуулснаас хойш 12 сар байна.

2.4. Усны эх үүсвэрийн байршил:

- Унд ахуйд ашиглах усыг Чандмань сумын Талын шанд багийн Талын худгаас авч ашиглана. (45°19'57.9", 97°59'19.4)
- Зам талбайн тоосжилт бууруулах зориулалтаар ашиглах усыг Чандмань сумын 3-р багийн нутагт байрлах Гоби Коул энд Энержи ХХК (шинэчлэгдсэн нэрээр

Сэкер Ресурсус Монголиа ХХК)-ийн ZMWB0058 гэсэн уурхайн техникийн усан хангамжийн зориулалттай худгаас авч ашиглана. (45°22'13.8", 97°53'35.8")

2.5. Ус ашигласны төлбөр:

2.5.1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тоот тушаалын хавсралт дахь “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу худагт тоолуур суурилуулан сумын татварын болон байгаль орчны хяналтын албаар баталгаажуулж усны төлбөрийг тоолуурын заалтыг үндэслэн төлнө.

2.5.2. Холбогдох хууль тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход:

а) Унд ахуйн зориулалтаар:

1м^3 Газрын доорх усны нөөц ашигласны төлбөр : $2,329\text{ м}^3/\text{жил} \times 81.48\text{ төг}/\text{м}^3$
 $= 189,832.1\text{ төг}/\text{жил}$ (нэг зуун наян есөн мянга найман зуун гучин хоёр төгрөг нэг мөнгө)-ийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэгт заасны дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын төрийн сангийн 100051500944 тоот дансанд төвлөрүүлэх;

б) Зам талбайн тоосжилт бууруулах зориулалтаар:

1м^3 Газрын доор усны нөөц ашигласны төлбөр: $9600\text{м}^3/\text{жил} \times 108,64\text{төг}/\text{т}^3$
 $= 1,042,944\text{ төг}$ (нэг сая дөчин хоёр мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг)-ийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймгийн Төрийн сангийн 100050000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

2.6. Талуудын эрх, үүрэг: Талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2 болон 31.1-д тус тус заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

2.7. Бусад зүйл:

2.7.1. Ус ашиглах явцын зардлыг ус ашиглагч хариуцна.

2.7.2. Гэрээ байгуулагч талууд Монгол Улсын Усны тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.7.3. Ус ашиглуулагч нь Ус ашиглагч талд энэ гэрээнд заасан хэмжээгээр усыг саадгүй ашиглах боломж нөхцөлөөр хангах үүрэгтэй. Аливаа шалтгаанаар усыг чөлөөтэй ашиглахад саад учирсан тохиолдолд талуудын тохирсон байршил, худгаас өөр байршлаас авах боломжоор бүрэн хангах үүрэгтэй.

2.7.4. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.7.5. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

2.7.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шүүхээр шийдвэрлүүлнэ.

2.7.7. Гэрээний нөхцөлийг биелүүлээгүй, дутуу биелүүлсэн бол буруутай тал холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

"ЧАНДМАНЬ" СУМЫН
БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН БАЙЦААГЧ



Б.ӨЛЗИЙСАЙХАН /

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК- НИЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН



Ч.ТӨРБАТ /

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар **032**...

Алтай хот
утас, факс: 70484955

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар. "Сэкер Ресорсус Монголиа" ХХК, Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил махатма ганди гудамж, "Корпорэйт зочид буудал энд конвеншн центр" 6 давхар, Гүйцэтгэх захирал Б.Баттуул, Утас: 99083245, 99918876 Улсын бүртгэлийн дугаар 9019097451, Регистрийн дугаар 2862468

2. Төслийн нэр, байршил. Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт байршилтай ба Улаанбаатар хотоос баруун зүгт 965 км, Алтай хотоос зүүн урагш 230км, Чандмань сумын төвөөс баруун хойш 9 километр зайд байрлах ба Хяргас нуур-Завхан голын сав газарт оршино.

3. Төсөл хэрэгжүүлэгч – "Сэкер Ресорсус Монголиа" ХХК

4.Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/. Тусгай зөвшөөрлийн дугаар: № MV-000905, MV-011965, MV-014217, MV-017438 (Нийт талбай – 483.3 га)

д/д	Тусгай зөвшөөрлийн талбай	Уртраг			Өргөрөг		
		град	мин	сек	град	мин	сек
1	Шар хоолой MV -011965	97°	53°	17.21	45°	22°	17.69
2	Шар хоолой MV -011965	97°	53°	40.21	45°	22°	17.69
3	Шар хоолой MV -011965	97°	53°	40.21	45°	22°	51.5
4	Шар хоолой MV -011965	97°	52°	30.31	45°	22°	51.5
5	Шар хоолой MV -011965	97°	52°	30.31	45°	21°	51.5
6	Шар хоолой MV -011965	97°	53°	40.21	45°	21°	51.5
7	Шар хоолой MV -011965	97°	53°	40.21	45°	22°	1.5
8	Шар хоолой MV -011965	97°	53°	17.21	45°	22°	1.5
9	Зээгт MV -000905	97°	53°	40.21	45°	22°	1.5
10	Зээгт MV -000905	97°	53°	40.21	45°	22°	17.69
11	Зээгт MV -000905	97°	53°	17.21	45°	22°	17.69
12	Зээгт MV -000905	97°	53°	17.21	45°	22°	1.5
13	Шар хоолой MV-014217	97°	54°	30.31	45°	21°	51.5
14	Шар хоолой MV-014217	97°	54°	30.31	45°	22°	51.48
15	Шар хоолой MV-014217	97°	53°	40.21	45°	22°	51.5
16	Шар хоолой MV-014217	97°	53°	40.21	45°	21°	51.5
17	Асгат MV-017438	97°	54°	54.31	45°	21°	51.5
18	Асгат MV-017438	97°	53°	50.32	45°	21°	51.5
19	Асгат MV-017438	97°	53°	50.31	45°	21°	17.5
20	Асгат MV-017438	97°	54°	54.31	45°	21°	17.5

5.Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт. Нүүрс олборлох ил уурхай

6.Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал. Газрын гадаргаас доош эхний 10 метр хөрсийг тэсэлгээгүй шууд ухаж ачна. Харин үүнээс доош өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлж автотээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр Caterpillar CAT 390 маркийн 11 ширхэг экскаватороор хийж гүйцэтгэнэ. Хөрс тээвэрт АНУ-д үйлдвэрлэсэн САТ брэндийн 777 маркийн 100 тонны даацтай автосамосвал 5 ширхэг, БНХАУ-ын

ХСМГ брэндийн ХДМ80 маркийн 80 тонны даацтай 9 ширхэг автосамосвалуудын хослолоор ажиллахаар тооцсон. Мөн "Эрхэт Түнш" ХХК нь гэрээний дагуу өөрийн техникуудээр хийж гүйцэтгэнэ. Хоногт 2 ээлжээр 353 хоног ажиллана.

7.Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ. 2025 онд нийт талбайд 6,5 сая.м³ хөрс хуулах ажил хийж гүйцэтгэнэ.

8.Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ. Хүн амын ундны усны хэрэглээнд Талын шанд багийн Талын худагас авч ашиглана. Чандмань сумын 3-р багийн нутагт байрлах Гоби Коул энд Энержи ХХК-ийн ZMWB0058 гэсэн уурхайн техникийн усан хангамжийн зориулалттай худагас зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах усаа Shaanxi ZOL5266GSS машинаар зөөж ашиглана. Унд ахуйн зориулалтаар 6.6м³/хоног, технологийн хэрэгцээнд 27,2 м³/хоног, нийт 33,8м³/ ус хэрэглэнэ.

9.Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/- Талын худаг нь 1,5л/сек ундаргатай, 2х3м хэмжээтэй бетон блокон барилгатай, шугам сүлжээгүй, уурхайн худаг нь 9,8л/с ундаргатай, барилгагүй

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/- Талын худаг АКАНKE-3800 маркийн ус өргөгч, Зээгтийн худагт Повер-1800 маркийн ус өргөгч, 220V маркийн хөдөлгүүртэй, насосуудыг 80м гүнд байрлуулав. Усны тоолуургүй

Талын худгийн байршил 45°19' 57.9" 97° 59' 19.4"

Зээгт удгийн байршил 45° 22' 13.8" 97° 53' 35.8"

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл. 2020 онд БОННУ-ний нэмэлт тодотголыг "Их Монголын Байгаль" ХХК хийж гүйцэтгэсэн.

12. Онцгой нөхцөл-

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын 2, 12, 13 дугаар хавсралтад заасны дагуу тооцоход:

Ажилчдын унд ахуйд хэрэглэх усны хэмжээ:

150 л/хон х 44 хүн х 353 хоног = 2,329.8м³/жил

Ажилчдын тоо-44 хүн

1 хүн хоногт хэрэглэх усны хэмжээ-150 л/хон

(Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаал)

Ажиллах нийт хоног-353 хоног

Зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээ:

100 хон х 48,000м² х 1х 2л/м²=9,600м³/жил

Услах хоног - 100 (хайгуулын ажлын төлөвлөгөөг үндэслэв хуурайшилтын үеийг тохируулан 7 хоногт 2 удаа
услахаар тооцролов)

Услагдах талбай – 48000м² (Холбогдох албан тушаалтны мэдээллийг үндэслэв

7 хоногт – 2 удаа

1м² газрын тоосжилт дарахад ашиглагдах хэмжээ – 2л (2015 оны А/301 дугаар
тушаалын 13 дугаар хавсралтын 7)

Жилд ашиглах нийт усны хэмжээ: 2,329.8м³+9,600м³=11,929.8м³/жил

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход. Унд ахуйн зориулалтаар ашиглах 2,329.8м³ газрын доорх усыг Засгийн газрын 2011 оны

302 дугаар тогтоолоор Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 тоот тогтоолыг үндэслэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 заалт, Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай Засгийн газрын 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10-т заасан хувь хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

1м³ усны нөөц ашигласны төлбөр : 2716 төг/м³ x 0.3 x 0.10 = 81.48төг/м³

2716төг/м³ – Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон газар доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэ,

0.3–Хүн амын унд ахуйн зориулалтаар газрын доорх ус ашиглалтыг тооцох итгэлцүүр,

10% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ

Унд ахуйн усны төлбөр: 2,329.8м³ x 81.48 төг/м³ = 189,832.1

/нэг зуун наян есөн мянга найман зуун гучин хоёр төгрөг арван мөнгө /-г “Төсвийн тухай” хуулийн 23.8 дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын төсөвт төвлөрүүлэх.

Зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах 9,600м³ газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 тогтоолоор Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолын хувь хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

Зам талбайн тоосжилтод 1м³ ус ашигласны төлбөр:

2716 x 0.2 x 20% = 108,64 төг/м³

2716 төг/м³– Хяргас нуур-Завхан голын сав газрын газрын доорх усны экологи

эдийн засгийн суурь үнэлгээ

0.2 – Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын авто зам засварт ашигласан газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

20% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4-т заасан хувь, хэмжээ

төлбөр: 9,600м³/жил x 108,64төг/м³ = 1,042,944 төг

/нэг сая дөчин хоёр мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг/-ийг “Төсвийн тухай” хуулийн 23.6.5 дахь заалтын дагуу 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотод багтаан Говь-Алтай аймгийн Төрийн сан банкны усны төлбөрийн 100050000944 тоот дансанд төвлөрүүлнэ үү.

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар. Нормын дагуу шаардагдах усыг авч хайгуулын өрөмдлөг, ажиллагсдын ахуйн хэрэгцээнд ашиглан хөрсөнд нэвчүүлэн устгах.

16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж


- Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн “Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авах:
- Мөн хуулийн 28.11-д заасны дагуу Чандмань сумын Засаг даргатай гэрээ байгуулж, ус ашиглах эрхийн бичиг авснаар танай байгууллагын энэ оны ус ашиглах эрх үүсэх болно.
- Мөн хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах:
- Мөн хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч,

жил бүрийн ажлын төлөвлөгөө, календарьчилсан графикийг үндэслэлтэй, үнэн зөв гарган ирүүлж байх:

- Худагт тоолуур суурилуулан сумын татварын болон байгаль орчны хяналтын албаар баталгаажуулж усны төлбөрийг тоолуурын заалтыг үндэслэн тооцож байх;
- Мөн хуулийн 24.1-д заасан Усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, машин техник, бохир зүйл угаахыг хориглоно гэсэн шаардлагыг ханган ажиллах;
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал, жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөн ажиллаж, хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх;
- Мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчид тавигдах шаардлага болон ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлэхэд "Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS4943:2015 стандартыг мөрдөн ажиллах.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/82/128 тоот хамтарсан тушаал батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллах.
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор багтаан БОГ-т ирүүлэх.

ХЯНАСАН:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.СОДМАА

БОЛОВСРУУЛСАН:

ХБОБН-ИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.АЛТАНСҮХ



БАТЛАВ:
“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК

Б.БАТТУУЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ ХБ-25/122,

2025 оны 06-р сарын 27-ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “гэрээ” гэх)-г

Нэг талаас “Элемент” ХХК (РД: 2100061) (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун,

Нөгөө талаас “Сэкер Ресорсус Монголиа” ХХК (РД: 2862468) (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн албан тушаалтай Б.Мядагбадам

